

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.	Аудитын тайлан	10
3.1.	ОРШИЛ	10
3.2	БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	10
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4	Материаллаг байдал	11
3.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1	Мөнгөн хөрөнгө	11
3.5.2	Авллага	12
3.5.3	Урьдчилгаа	13
3.5.4	Бараа материал	13
3.5.4	Үндсэн хөрөнгө	14
3.5.5	Өр төлбөр	14
3.5.6	Засгийн газрын хувь оролцоо	15
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	16
3.7	Шилэн дансны мэдээлэл	18
3.9	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	19
3.10.	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	20
4.	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	20
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.22 № 420
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.АМГАЛАНБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030652

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/ мянган төгрөгөөр/	
			2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		650,823.80	868,748.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	125,866.80	309,332.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	287,038.90	352,166.70
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	52,860.10	0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	185,058.00	200,749.70
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0	6,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,649,162.70	3,617,602.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,649,162.70	3,617,602.50
39200	Биет хөрөнгө		3,602,650.20	3,571,241.00
39300	Биет бус хөрөнгө	13	46,512.50	46,361.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,299,986.50	4,486,351.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		96,154.00	1,915.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	96,154.00	1,915.00
41300	Өглөг	17а, 17б	96,154.00	1,915.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,203,832.50	4,484,436.30
51	Засгийн газрын хувь оролцоо		4,203,832.50	4,484,436.30
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		796,749.10	791,801.00
51200	Хуримтлагдсан үр дүн		2,156,074.60	2,010,953.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,251,008.80	1,681,681.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,299,986.50	4,486,351.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,927,105.10	2,410,797.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		68,168.40	259,899.40
110	Орлогын албан татвар		59,151.30	49,919.30
1100	Хувь хүний орлогын албан татвар		59,151.30	49,919.30
113	Хөрөнгийн албан татвар		698	69,489.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		8,319.00	140,490.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,252,020.60	201,097.10
120	Нийтлэг татварын бус орлого		1,252,020.60	201,097.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,606,916.10	1,949,801.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,797,179.80	1,945,095.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,797,179.80	1,945,095.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,691,289.80	1,843,992.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		857,091.60	918,075.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		114,124.40	119,011.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		336,153.70	253,984.90
2104	Хангамж, бараа материалын зардал		49,360.40	63,978.20
2105	Нормативт зардал		38,760.20	104,577.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		36,760.60	34,722.20
2107	Томилолт, зочны зардал		13,792.00	7,440.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		47,056.50	49,607.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		198,190.30	292,594.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		105,890.00	101,102.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,129,925.30	465,702.60
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	4,873.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,535.80	156,983.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,127,389.50	313,593.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан



Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		1,716,683.20	2,157,415.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО		68,168.40	259,899.40
110	Орлогын албан татвар		59,151.30	49,919.30
1100	Хувь хүний орлогын албан татвар		59,151.30	49,919.30
113	Хөрөнгийн албан татвар		698.00	69,489.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		8,319.00	140,490.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		7,855.70	6,875.80
1181	Газрын төлбөр		353.40	877.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		110.00	132,737.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		39,570.00	33,862.10
120	Нийтлэг татварын бус орлого		39,570.00	33,862.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,608,944.80	1,863,653.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,608,710.00	1,822,129.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,608,710.00	1,822,129.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,502,529.50	1,720,013.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		857,145.30	916,184.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		113,275.10	119,186.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		244,314.70	344,933.90
2104	Хангамж, бараа материалын зардал		77,142.10	49,260.30
2105	Нормативт зардал		35,826.60	135,752.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		53,628.90	25,759.90
2107	Томилолт, зочны зардал		13,792.00	7,240.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		53,382.40	46,681.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		54,022.40	75,014.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		106,180.50	102,115.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		107,973.20	335,286.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		93,824.70	151,820.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		93,824.70	151,820.40
2200	Дотоод эх үүсвэрээр		93,824.70	151,820.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(93,824.70)	(151,820.40)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		14,148.50	183,465.60
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		111,718.30	125,866.80
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		125,866.80	309,332.40

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,077,083.60	-	3,077,083.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(640.60)	-	(640.60)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,076,443.00	-	3,076,443.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	1,127,389.50	-	1,127,389.50
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,203,832.50	-	4,203,832.50
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,203,832.50	-	4,203,832.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(28,115.60)	-	(28,115.60)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,175,716.90	-	4,175,716.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	(4,873.70)	-	(4,873.70)
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	313,593.10	-	313,593.10
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,484,436.30	-	4,484,436.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,170,780.50	1,762,124.84	408,655.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,773,720.90	1,649,526.34	124,194.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,751,090.70	1,629,880.09	121,210.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	947,643.60	916,184.18	31,459.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,942.20	119,186.66	17,755.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	356,538.20	344,933.94	11,604.26
2104	Хангамж, бараа материалын зардал	45,166.70	43,867.17	1,299.54
2105	Нормативт зардал	104,555.40	67,273.33	37,282.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,102.10	54,835.61	266.50
2107	Томиллот, зочны зардал	7,457.20	6,990.90	466.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,414.40	28,003.27	3,411.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,270.90	48,605.03	17,665.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,630.20	19,646.25	2,983.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,630.20	19,646.25	2,983.95
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,633.60	4,738.01	2,895.59
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,620.50	112,598.50	35,022.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	249,439.10	-	249,439.10
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,170,780.50	1,825,706.31	345,074.19
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	914,508.80	860,042.31	54,466.49
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	935,519.70	931,001.52	4,518.18
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,919.10	11,909.16	12,009.94
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	296,832.90	22,753.32	274,079.58
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	53,778.42	(53,778.42)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	117,359.89	(117,359.89)
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.34	0.33	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.01	0.01	-
610001	Төсвийн байгууллага	0.01	0.01	-
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.09	0.09	0.00
620001	Удирдах ажилтан	0.01	0.01	-
620002	Гүйцэтгэх ажилтан	0.05	0.05	-
620003	Үйлчлэх ажилтан	0.02	0.02	-
620004	Гэрээт ажилтан	0.01	0.01	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	231714420 / 157,358.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	СЦА.00043 907 / 157,358.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,355.53
2104	Хангамж, бараа материалын зардал	5,393.16
2105	Нормативт зардал	68,479.16
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,388.15
2107	Томиллот, зочны зардал	249.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,367.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,477.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,002.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,425.80
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	577.06
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,253.01
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,253.01
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,894.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,894.62

3. Аудитын тайлан

3.1. Оршил

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох, авлагыг барагдуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Төсвийн тухай хуульд “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 5.4.-д Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Баянхутаг сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,580.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 25.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 635.5 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 14.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 125.8 сая, эцсийн үлдэгдэл 309.3 сая төгрөг болж, 183.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	125.87	309.02	183.15	99.83
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	0.31	0.31	0.17
Дүн	125.87	309.33	183.46	100.00

Эх сурвалж: Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 188.8 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн 83.4 сая, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 14.8 сая, Сум хөгжүүлэх сангийн 14.9 сая, Байгаль хамгаалах сангийн 0.8 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 5.3 сая, нийт 308.0 сая төгрөг төрийн сангийн харилцахад, Эмийн эргэлтийн сангийн 1.0 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд байршиж байна. Замд яваа мөнгөний үлдэгдэлд хөрөнгийн орлогын 0.3 сая төгрөг байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 73.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 54.5 сая төгрөгийг улсын төсөвт, нийт 128.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Байгууллагаар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2. Төвлөрүүлсэн үлдэгдэл

/сая төгрөг/

Байгууллага	Төвлөрүүлсэн үлдэгдэл						Нийт
	Улсын төсөвт			Орон нутгийн төсөвт			
	Үндсэн данс	Нэмэлт данс	Нийт	Үндсэн данс	Нэмэлт данс	Нийт	
ИТХ			-	1.0		1.0	1.0
ЗДТГ			-	46.3	0.5	46.8	46.8
ЕБС	41.0		41.0	4.4		4.4	45.4
ЭМТ			-	0.1		0.1	0.1
Цэцэрлэг	13.5		13.5	0.1		0.1	13.6
Соёлын төв			-	21.1	0.1	21.2	21.2
Дүн	54.5	-	54.5	72.9	0.6	73.5	128.0

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой 0.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. **Цэцэрлэг цахим төлбөрийн баримтгүйгээр 0.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.**

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 287.0 сая, эцсийн үлдэгдэл 352.1 сая болж 65.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.0	(0.0)
Төлбөртэй үйлчилгээний авлага		86.1	86.1
Дансны авлага /ТӨҮГ/	2.3		(2.3)
Бусад авлага			-
Байгууллагаас авах авлага	0.3	1.4	1.1
Хувь хүнээс авах авлага	1.0	1.0	-
Зээлийн авлага	283.4	263.6	(19.8)
Дүн	287.0	352.1	65.1

Эх сурвалж: Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төлбөртэй үйлчилгээний авлага нь Эрүүл мэндийн төвд ЭМДС-аас олгох Ковид-19 цар тахлын санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдэл 172.3 сая, Жижиг дунд бизнесийг дэмжих сангийн үлдэгдэл 91.3 сая төгрөг байна. Нийт авлагын 74.9 хувийг зээлийн авлага эзэлж байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд Цэцэрлэгийн өмнөх онд урьдчилж гарсан 5.5 сая, ЕБС-ийн 3.2 сая, ОНХС-ийн 44.2 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалын зардал бүртгэсэн байсныг хөрөнгийг орлого авч үлдэгдэлгүй болсон байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 185.1 сая, эцсийн үлдэгдэл 207.2 сая төгрөг болж, 15.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	12.9	38.0	25.1
Тусгай зориулалттай материал			-
Эм боох материал	12.9	38.0	25.1
Дуусаагүй үйлдвэрлэл			-
Хангамжийн материал	165.7	155.1	(10.6)
Бичиг хэргийн материал	7.8	6.4	(1.4)
Аж ахуйн материал	117.5	113.0	(4.5)
Сэлбэг хэрэгсэл	3.3	2.5	(0.8)
Түлш, шатах тослох материал	0.8	0.5	(0.3)
Барилгын засварын материал	17.9	9.3	(8.6)
Хүнсний материал	2.5	7.0	4.5
Бусад хангамжийн материал	15.9	16.4	0.5
Мал амьтад	6.5	7.6	1.1
Нөөцийн бараа		6.5	
Дүн	185.1	207.2	15.6

Эх сурвалж: Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 299.6 сая төгрөгийн бараа материалыг орлого авснаас 278.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 21.2 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Нийт 277.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт: Бараа материалын данстай холбоотой 0.6 сая төгрөгийн зөрчил илэрснийг тухайн байгууллагуудын санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- ЭМТ** - Эм боох материалын үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангаас 0.5 сая, бичиг хэргийн материал 0.01 сая төгрөгөөр илүү, аж ахуй материал дансны үлдэгдэл 0.05 сая, хүнсний материалыг 0.02 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Соёлын төв** - Номын эхний үлдэгдлийг 0.04 сая төгрөг дутуу тайлагнасан.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,338.3 сая, эцсийн үлдэгдэл 4,547.9 сая төгрөг болж, 209.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,289.2	4,498.7	209.6
Барилга, байгууламж, орон сууц	3,205.0	3,255.7	50.7
Авто-тээврийн хэрэгсэл	206.7	218.5	11.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	373.7	450.9	77.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	147.9	155.1	7.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8.2	8.2	-
Бусад үндсэн хөрөнгө	335.1	397.7	62.7
Дуусаагүй барилга, байгууламж	0.0	0.0	-
Ном	12.5	12.6	0.0
Биет бус хөрөнгө	49.2	49.2	-
Программ хангамж	3.6	3.6	-
Бусад биет бус хөрөнгө	45.5	45.5	-
Дүн	4,338.3	4,547.9	209.6

Эх сурвалж: Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс худалдаж авсан 39.2 сая, хандиваар 0.4 сая, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 171.1 сая, нийт 210.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, Эмийн эргэлтийн сангийн 1.1 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой 29.3 сая төгрөгийн зөрчил илэрснийг тухайн байгууллагуудын санхүүгийн тайланд зарлуулав. Үүнд:

- ЭМТ** - Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 28,0 сая төгрөгөөр, тайлант хугацаанд 11 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийг 1.3 сая төгрөгөөр дутуу тооцоолсон.
- Соёлын төв** - тавилга, аж ахуйн эд хогшил дансны эхний үлдэгдлийг 0.05 сая төгрөг илүү тайлагнасан.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 96.1 сая, эцсийн үлдэгдэл 1.9 сая төгрөг болж, 94.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	91.0	1.8	(89.2)
Ажиллагсадтай холбогдсон өглөг	0.0	1.8	1.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	91.0	0.0	(91.0)
Бусад өглөг	5.1	0.1	(5.0)
Байгууллагад төлөх өглөг	0.1	0.1	0.0
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0		(0.0)
Татварын өглөг /ТӨҮГ/	0.1		(0.1)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.1		(0.1)
Дансны өглөг /ТӨҮГ/	4.8		(4.8)
Нийт дүн	96.1	1.9	(94.2)

Эх сурвалж: Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэл буурсан нь ТЗШ-ийн байгууллагууд өмнөх оны халаалтын өрийг төлж барагдуулсантай холбоотой. Эцсийн үлдэгдэлд ЕБС-ийн ХХОАТ-ын 1.8 сая төгрөгийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Зардлын данстай холбоотой 1.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. **ЕБС** - НББ-ийн анхан шатны баримтыг үндэслэлгүйгээр ХХОАТ-ын өглөг 1.8 сая төгрөгийн өглөг үүсгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,203.8 сая, эцсийн үлдэгдэл 4,484.4 сая болж, 280.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

/САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	796.7	791.8	(4.9)	22.1
Хуримтлагдсан үр дүн:	2,156.1	2,010.9	(145.2)	47.8
Өмнөх үеийн үр дүн	1,028.7	1,697.3	668.6	
Тайлант үеийн үр дүн	1,127.4	313.6	(813.8)	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,251.0	1,681.7	430.7	30.1
Дүн	4,203.8	4,484.4	280.6	100.0

Эх сурвалж: : Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 791.8 сая болж 4.9 сая төгрөгөөр буурсан нь Эмийн эргэлтийн сан татан буугдсантай холбоотой.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 313.6 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ-ийн элэгдлийн залруулга 28.0 сая, ЕБС-ийн барилгын дахин үнэлгээний зөрүүг залруулсан 430.7 сая, нийт 458.7 сая төгрөгөөр буурч 2,010.9 сая төгрөг болсон байна.

3.5.7 Орлогын данс

Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь татварын орлого 259.9 сая, татварын бус орлого 201.1 сая, тусламж санхүүжилтийн орлого 2,939.4 сая, нийт 3,400.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Үйл ажиллагааны нийт зардал 2,934.7 сая, үйл ажиллагааны бус зардал 157.0 сая төгрөг байна. Үйл ажиллагааны бус зардал нь ОНХС-ийн 157.8 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг үнэ төлбөргүй гарсан зардал дансанд бүртгэсэнтэй холбоотой.

Аудитын илрүүлэлт: Зардлын данстай холбоотой 7.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. **ЕБС** - НББ-ийн анхан шатны баримтыг үндэслэлгүй журнал бичилт хийж цалингийн зардлыг 2.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг санхүүгийн тайланд залруулав.
2. **Цэцэрлэг** - Ажиллагсдын 4.2 сая төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд мэдүүлээгүй, ерөнхий журнал, цалингийн хүснэгт зөрүүтэй илэрхийлсэн 1.5 сая төгрөг нийт 5.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхутаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 08 дугаар сарын 30-ны 01 дүгээр тогтоолд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 84.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 270.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 185.6 сая төгрөгөөр буюу 319.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2021 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	20.0	20.4	0.4	102.0
2	Хөрөнгө борлуулсны орлого		6.4	6.4	
3	Хөрөнгийн орлого	7.0	23.1	16.1	330.0
4	Бууны албан татвар	1.6	1.1	(0.5)	68.8
5	Улсын тэмдэгтийн хураамж	1.0	0.3	(0.7)	30.0
6	Түгээмэл тархацтай АМНАТ	0.3	1.0	0.7	333.3
7	Хог хаягдлын хураамж	7.7	5.6	(2.1)	72.7
8	Агнуурын нөөц ашигласны төлбөр	38.7	132.7	94.0	342.9
9	Газрын төлбөр	1.0	0.9	(0.1)	90.0
10	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.2	-	(0.2)	-
11	Торгуулийн орлого	7.0	9.0	2.0	128.6
12	Бусад орлого		1.2	1.2	
13	Малын тоо толгойн албан татвар		68.4	68.4	
Нийт дүн		84.5	270.1	185.6	319.6

Орлогын төлөвлөгөө давж биелсэн нь төлөвлөгдөөгүй шонхор шувуу тусгай зөвшөөрлөөр бариулсны төлбөрийн орлого орсон, малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна. Засгийн газраас Ковид -19 цар тахалтай холбоотой иргэдийн хог хаягдлын хураамжийг чөлөөлснөөс хог хаягдлын хураамжийн орлого тасарсан байна.

Аудитын илрүүлэлт: Татварын орлогын гүйцэтгэлтэй холбоотой 3.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

ТТЗ: Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.2 сая, бууны албан татвар 0.5 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.1 сая, газрын төлбөр 0,1 сая нийт 3.6 сая төгрөгөөр орон нутгийн төлбөр хураамжийн орлогыг дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх талаар зөвлөмж хүргүүлнэ.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн татварын орлогыг 92.8 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8.3 сая төгрөгөөр бууруулж 84.5 сая төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 2,170.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,170.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,773.7 сая төгрөгийг урсгал зардалд, 147.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 249.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 690.8 сая төгрөгөөр батлагдсаныг бүрэн олгосон байна.

Нийт зардлыг тусгай зориулалтын шилжүүлгээс 914.5 сая, орон нутгийн төсвөөс, 848.4 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 87.1 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 23.9 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 242.5 сая, урьд оны үлдэгдлээс 54.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

- Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Орон нутгийн хөгжлийн санд малын тоо толгойн албан татварын 68.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.
- ЭМТ-д ЭМДС-аас 23.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 11.9 сая төгрөг олгож, 12.0 сая төгрөгийг дутуу олгосон байна.
- Үндсэн үйл ажиллагааны орлогод 19.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг Сум хөгжүүлэх сан 147.4 сая, Жижиг дунд бизнесийг дэмжих сан 73.4 сая төгрөгөөр тус тус дутуу биелүүлсэн байна.
- Туслах үйл ажиллагааны орлого 2.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөнөөс 0.9 сая төгрөгөөр давуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,762.1 сая төгрөг буюу 81.2 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 121.2 сая төгрөг, хөрөнгийн зардал 35.0 сая төгрөг, эргэж төлөгдөх зээл 249.4 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 3.0 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил 31.5 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 17.7 сая, байр ашиглалтын тогтмол зардал 11.6 сая, хангамжийн бараа материалын зардал 1.3 сая, нормативт зардал 37.3 сая, эд хогшил худалдан авах зардал 0.3 сая, албан томилолтын зардал 0.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 3.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 17.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 127.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж Жаргалант, Цантын хоолой багуудын тохижилтын ажил хийгдээгүй байна.

Эргэж төлөгдөх зээл 249.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгох 88.1 сая, Сум хөгжүүлэх сангаас олгох 161.3 сая төгрөгийн зээлийг олгоогүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн, зориулалт бус зарцуулсан 2.7 сая, эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан 1.6 сая, нийт 4.3 сая төгрөгийн зөрчилд байгууллага тус бүрд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас
 - **ЗДТГ- "Өндөрхаан цахим өртөнц" ТББ-тай гэрээ байгуулан сумын онцлог үйл явдлыг олон нийтэд сурталчлан таниулахаар 0.6 сая төгрөгийн гэрээг байгуулан санхүүжүүлсэн, шагнал урамшуулал олгосон 2.1 сая төгрөг,**
2. Эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан:
 - **ЕБС - Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас тавилга худалдаж авсан 1.6 сая төгрөг, НББ-ийн анхан шатны баримтыг үндэслээгүйгээс цалингийн зардлаас ажил олгогчийн НДШ-д 0.2 сая төгрөг зарцуулсан,**

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд дээд шатны төсвийн захирагчаас 135.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 23.5 сая, нийт 159.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс:

Хангамжийн бараа материал худалдан авахад 5.4 сая, эм бэлдмэл нормативт зардалд 68.5 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 6.4 сая, томилолтын зардалд 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 21.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 27.5 сая, төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 27.4 сая, нийт 156.8 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 0.01 сая, орон нутгийн төсөвт 0.6 сая төгрөгийг шилжүүлж 1.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төсвийн төвлөрүүлэн захирагч шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 105.7 сая төгрөгийн 136 мэдээллээс 54 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах зөвлөмж хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 265.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд

ЭМТ-ын 176.7 сая, Соёлын төвийн 89.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөгөөр/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	250.6			1	250.6	0
Зөвлөмж	3	203.5			3	203.5	0
Нийт	4	454.1			4	454.1	0

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлнэ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 төрийн сан, 4 тусгай сан, Эмийн эргэлтийн сан нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 төсвийн байгууллага, 1 төрийн санд аудит хийж, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Жижиг дунд бизнесийг дэмжих сан, Байгаль хамгаалах сан, Сум хөгжүүлэх сангууд аудитын түүвэрт хамрагдаж, Эмийн эргэлтийн сан аудитад хамрагдаагүй болно.

Д/д	Байгууллагын нэр	Аудитад хамрагдсан байдал			Дүгнэлтийн хэлбэр			
		Дүгнэлт	Түүвэрт	Хамрагдаагүй	Зөрчилгүй	Хязгаар-лаптай	Сөрөг	Татгалзсан
1	Засаг дарга	+			+			
2	ЗДТГазар	+			+			
3	ЕБСургууль	+			+			
4	Цэцэрлэг	+				+		
5	Эрүүл мэндийн төв	+			+			
6	Соёлын төв	+						
7	ИТХурал		+					
8	Орон нутгийн хөгжлийн сан		+					
9	Байгаль хамгаалах сан		+					
10	ЖДБДСан		+					
11	Сум хөгжүүлэх сан		+					
12	Эмийн эргэлтийн сан			+				
	ДҮН	6	5	1	4	1	-	-

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Баянхутаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Өндөрхаан итгэл аудит” ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн.

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар ЗДТГ, ЕБС, ЭМТ, Соёлын төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 310.5 сая төгрөгийн 13 алдаа, зөрчил илрүүлснээс 32.2 сая төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулж, 277.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 албан шаардлага хүргүүлж, 0.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3.6 сая төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.
Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төвлөрүүлэн захирагчид акт, албан шаардлага хүргүүлээгүй.

Төвлөрүүлсэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 3.6 сая төгрөгийн зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.2 сая, бууны албан татвар 0.5 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.1 сая, газрын төлбөр 0,1 сая нийт 3.6 сая төгрөгөөр орон нутгийн төлбөр хураамжийн орлогыг дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл: Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлээгүй байх.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтын дагуу төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2022.04.10	Аудитын нэр:	Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: ХЭА-2022/02/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч		сая төгрөгөөр

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	"Өндөрхаан цахим өртөнц" ТББ-тай гэрээ байгуулан сумын онцлог үйл явдлыг олон нийтэд сурталчилан таниулахаар 600.0 мянган төгрөгийн гэрээг байгуулан санхүүжүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түүвэрлэн тулгахад 2130.6 мянган төгрөгийн шагнал урамшуулалын зардалд зарцуулсан байна.	2.7	Албан шаардлага өгсөн	Дарга, Нягтлан бодогч	Б.Золбоо, Х.Энхцэцэг
ЗДТГ-ын дүн		2.7			
1	НББ-ийн анхан шатны баримтыг үндэслээгүйгээс цалингийн зардлыг дутуу тусгасан 2167.8 мянган төгрөгийн бичилтийг залруулж хийлгэв.	2.2	Залруулга хийсэн	Захирал, нягтлан бодогч	М.Тунгалагтуяа, Н.Ууганнавч
2	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас 1,642,900 төгрөгөөр тавилга худалдаж авсан байна.	1.6	Албан шаардлага өгсөн	Захирал, нягтлан бодогч	М.Тунгалагтуяа, Н.Ууганнавч
3	НББ-ийн анхан шатны баримтыг үндэслээгүйгээс цалингийн зардлаас ажил олгогчийн НДШ-д 221.5 мянган төгрөг зарцуулсан, ХХОАТ-ын өглөг 1767.3 мянган төгрөгийг өглөг үүсгэсэн байна.	2.0	Албан шаардлага өгсөн	Захирал, нягтлан бодогч	М.Тунгалагтуяа, Н.Ууганнавч
ЕБС-ын дүн		5.8			
1	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн хуримтлагдсан элэгдэл санхүүгийн тайланд 28,040.2 мянган төгрөгөөр дутуу тусгагдсан байна.	28.0	Залруулга хийсэн	Дарга, Нягтлан бодогч	А.Сувд-Эрдэнэ, Х.Энхцэцэг
2	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 11 хөрөнгийн элэгдлийг 1,273.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон байна.	1.3	Залруулга хийсэн	Дарга, Нягтлан бодогч	А.Сувд-Эрдэнэ, Х.Энхцэцэг

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Эм боох материалын үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангаас 510,1 мянган төгрөг, бичиг хэргийн материал 14.0 мянган төгрөгөөр илүү, аж ахуй материал дансны үлдэгдэл 52.4 мянган төгрөг, хүнсний материал 15.8 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн байна.	0.6	Залруулга хийсэн	Дарга, Нягтлан бодогч	А.Сувд-Эрдэнэ, Х.Энхцэцэг
4	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 8 худалдан авалт 98.7 сая төгрөг, 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр болох 78.0 сая төгрөгийн 8 гүйлгээг шилэн дансны нэгдсэн системд мэдээлээгүй байна.	176.7	Албан шаардлага өгсөн	Дарга, Нягтлан бодогч	А.Сувд-Эрдэнэ, Х.Энхцэцэг
	ЭМТ-ийн дүн	206.6			
1	Е баримтгүй худалдан авалт хийсэн.	0.4	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Энхтайван, Н.Ууганнавч
2	Ажиллагсадын цалинг НДШийн тайланд мэдүүлээгүй	4.2	Албан шаардлага өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Энхтайван, Н.Ууганнавч
3	Ерөнхий журнал, цалингийн хүснэгт зөрүүтэй	1.5	Албан шаардлага өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Энхтайван, Н.Ууганнавч
	Цэцэрлэгийн дүн	6.1			
1	Санхүүгийн тайланд тавилга, аж ахуйн эд хогшил дансны эхний үлдэгдэл 45,984.6 төгрөгөөр илүү, ном 45,000.0 төгрөгөөр дутуу тайлагнасан.	0.1	Залруулга хийсэн	Эрхлэгч, нягтлан бодогч	С.Мөнххэрлэн, Н.Ганлхагва
2	Шилэн дансанд мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 68.0 сая төгрөгийн 10, зарлагын 21.1 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 89.1 сая төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй, төсвийн гүйцэтгэлийг 3-р улиралд, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	89.2	Албан шаардлага өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	С.Мөнххэрлэн, Н.Ганлхагва
	Соёлын төвийн дүн	89.3			

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Шилэн дансны сайтад мэдээлвэл зохих 105.7 сая төгрөгийн 136 мэдээллээс 54 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, САД бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч	Б.Амгаланбат, Х.Энхцэцэг
2	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.2 сая, бууны албан татвар 0.5 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.1 сая, газрын төлбөр 0,1 сая нийт 3.6 сая төгрөгөөр орон нутгийн төлбөр хураамжийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	3.6	Зөвлөмж өгөх	Засаг дарга, САД бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч	Д.Жамбаа, Б.Энхжаргал
	ТТЗ -ийн дүн	3.6			
	Нийт дүн	314.1			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 22

Дугаар 245/А2370452
ХТЭА 2022/02/НА СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянхутаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар хүргүүлсэн 1 албан шаардлага, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлэх, СХС, ЖДБДС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэсэн заалтад нийцээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхутаг сумын Засаг дарга Б.Амгаланбат, санхүү албаны даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Х.Энхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ХУЛАНХАТАН

Д.ОЮУНТУЯА